



НИЙСЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

“Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг” шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16,5,1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, шинээр худалдан авах, шилжүүлэх, зориулалтын дагуу эзэмшүүлэх, ашиглуулах, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах эрх бүхий өмч хөрөнгийг хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Газрын орлогч дарга
Гишүүд:	Захиргааны хэлтсийн дарга Хүний нөөцийн мэргэжилтэн Инновацийн мэргэжилтэн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Вэб домайн хариуцсан мэргэжилтэн Нярав

2. Хууль, дүрэм, журамд заагдсан эрх үүргийн дагуу зөвлөлийн үйл ажиллагааг удирдан явуулахыг Зөвлөлийн даргад даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2016 оны А/43 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ЧИНЗОРИГ